



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/278

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Үенч сумын нутаг дэвсгэрт "Хөрс" ХХК-ний барьж гүйцэтгэсэн "Шатахуун түгээх станц"-ын байгууламжийн ажлыг хүлээн авах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Улсын комиссын дарга: З.Өмиртай – Аймгийн ерөнхий архитектор бөгөөд, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд Ц.Батбаяр - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч

А.Ганцоож - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Д.Очирбадам – Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч

Т.Ганболор – Газрын тосны орон нутгийн төлөөлөгч

Ч.Ганчимэг - "Хөрс" ХХК-ний орон нутгийн захирал

Нарийн бичгийн

дарга: Д.Тогтохбаяр – Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн

2. "Хөрс" ХХК барьж гүйцэтгэсэн "Шатахуун түгээх станц"-ын байгууламжийн ажлыг зураг, төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг улсын комиссын дарга / З.Өмиртай /-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

Zax A/278 Ch
02 61209